



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/26/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatar.e@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 261628 Цахим хаяг: battsetseg.p@audit.gov.mn Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Ц.Жигдэн Утас: 7000-5401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа	7
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
СЯ	Сангийн Яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ОСБ	Оролцогч санхүүгийн байгууллагууд
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН
ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ ЗАМААР ЭДИЙН
ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, АЖЛЫН
БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХСАЙХАН ТАНАА

2026.04.09 № 06/1017
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж нь тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд бүрэн шилжсэн ба 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр төслийн үйл ажиллагаа бүрэн хаагдсан.

Аудитын гол асуудал

Тайлант онд арилжааны 7 банкаар дамжуулан 15,695,300.0 мянган төгрөгийн батлан даалтыг санхүүжүүлсэн байна.

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж нь тайлант оны эцэст 450 жижиг, дунд үйлдвэрлэгчдийн 111,354,904.6 мянган төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсөл Хэрэгжүүлэх Нэгжийн тайлант оны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,289,757,872.76	4,367,531.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,216,436,475.03	4,367,531.27
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,216,436,475.03	4,367,531.27
31210	Төрийн сангийн харилцах	-	-
31211	Арилжааны банк дахь харилцах	1,216,436,475.03	4,367,531.27
33	АВЛАГА	8,073,321,397.73	-
33500	Бусад авлага	8,073,321,397.73	-
33510	Байгууллагаас авах авлага	8,073,321,397.73	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,289,757,872.76	4,367,531.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41361	Байгууллагад төлөх аглаг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,289,757,872.76	4,367,531.27
51	Засгийн газрын хувь оролцоо	9,289,757,872.76	4,367,531.27
51200	Хуримтлагдсан үр дүн	9,289,757,872.76	4,367,531.27
51210	Өмнөх үеийн үр дүн	56,319,780,141.52	9,285,757,872.76
51220	Тайлант үеийн үр дүн	(47,030,022,268.76)	(9,285,390,341.49)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,289,757,872.76	4,367,531.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	-
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	47,030,022,268.76	9,285,390,341.49
225001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх	46,984,999,296.40	9,285,390,341.49
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	45,022,972.36	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(47,030,022,268.76)	(9,285,390,341.49)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,279,846,575.51	204,588,907.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,279,846,575.51	204,588,907.67
120009	Бусад орлого	2,279,846,575.51	204,588,907.67
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,353,195,273.24	1,416,657,851.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,359,195,273.24	1,416,657,851.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,359,195,273.24	1,416,657,851.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,353,195,273.24	1,416,657,851.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,353,195,273.24	1,416,657,851.43
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(8,073,348,697.37)	(1,212,068,943.76)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(47,030,005,468.76)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	46,984,982,496.40	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	46,984,982,496.40	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	45,022,972.36	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	45,022,972.36	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(55,103,354,166.49)	(1,212,068,943.76)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	56,319,790,641.52	1,216,436,475.03
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,216,436,475.03	4,367,531.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,319,780,141.52	56,319,780,141.52
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,319,780,141.52	56,319,780,141.52
4	Тайлант үеийн үр дүн	(47,030,022,268.76)	(47,030,022,268.76)
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,289,757,872.76	9,289,757,872.76
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,289,757,872.76	9,289,757,872.76
8	Тайлант үеийн үр дүн	(9,285,390,341.49)	(9,285,390,341.49)
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,367,531.27	4,367,531.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,007,200,000.0	8,007,200,000.0	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ				
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	8,007,200,000.0	8,007,200,000.0	-	100.0
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	8,007,200,000.0	8,007,200,000.0	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				
	Балансын тохируулга		(1,212,068,943.76)		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,216,436,475.03	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,367,531.27	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Зээлийн батлан даалтын сангаас хэрэгжүүлж буй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл” нь “*жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид (ЖДҮ)-ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлэн өсөлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох*” зорилгоор Азийн хөгжлийн банк (АХБ)-ны 60,000.0 мянган ам.долларын санхүүжилтээр 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр батлагдсан.

Төслийн ашиглаагүй үлдэгдлийг зарцуулахаар Сангийн яамны 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/10218 тоот албан бичгээр Азийн хөгжлийн банканд хүргүүлснээр төслийн хэрэгжилтийн хугацааг 2025 оны 6 дугаар сарын 30-ний өдөр хүртэл сунгасан ба төслийн үйл ажиллагааг энэ өдрөөр хаасан байна.

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж нь оролцогч санхүүгийн байгууллага болох арилжааны 7 банкт хамтран тайлант онд 53 жижиг дунд үйлдвэрлэгчдэд 15,695,300.0 мянган төгрөгийн бизнесийн зээлийн хүрээний батлан даалтын эх үүсвэрийг санхүүжүүлсэн. Оролцогч санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулснаар 2025 оны эцэст 450 жижиг дунд үйлдвэрлэгчдийн 210,121,021.6 мянган төгрөгийн зээлд 111,354,904.6 мянган төгрөгийн батлан даалтын санхүүжилтийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 41 зээлдэгчийн 1,805,500.0 мянган төгрөгийн чанаргүй батлан даалтыг төлүүлснээс 10 зээлдэгчийн 978,900.0 мянган төгрөгийн чанаргүй батлан даалт бүрэн төлөгдсөн байна. Мөн 22 зээлдэгчийн 9,060,800.0 мянган төгрөгийн батлан даалт чанаргүй ангилалд шилжиж, 14 зээлдэгчийн 5,537,800.0 мянган төгрөгийн батлан даалтын ангилал дээшилж хэвийн ангилалд шилжсэн байна.

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Иргэний хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон бусад холбогдох дүрэм, журам, зааврыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” ;
- “2025 оны Төсвийн тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд төслийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,285,390.4 мянган төгрөгөөр буюу 99.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,216,436.5	4,367.5	(1,212,069.0)
Дансны авлага	8,073,321.4	-	(8,073,321.4)
Нийт хөрөнгө	9,289,757.9	4,367.5	(9,285,390.4)
Засгийн газрын хувь оролцоо	9,289,757.9	4,367.5	(9,285,390.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,289,757.9	4,367.5	(9,285,390.4)

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,367.5 мянган төгрөг болж өмнөх оноос 1,212,069.0 мянган төгрөгөөр буурсан нь АХБ-тай хийсэн хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагаа 2025 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөр бүр мөсөн хаагдсан тул

санхүүжилтээс ашиглаагүй үлдсэн 355,638.09 ам.долларын буюу 1,277,096.4 мянган төгрөгийг АХБ-д буцаан шилжүүлсэн, 4,367.5 мянган төгрөгийн үлдэгдлийг 2026 оны 06-р сарын 03-ны өдөр хугацаатай хадгаламжийн гэрээг цуцалж ЗБДС-н дансанд төвлөрүүлнэ.

- Авлага дансны үлдэгдэл 8,073,321.4 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь 57,831.4 мянган төгрөгийн бүтээгдэхүүний төрлийг буруу бүртгэсэн авлагыг 2025 оны 01-р сарын 02-ны өдөр, 8,007,180.0 мянган төгрөгийн батлан даалтын авлагыг 2025 оны 12-р сарын 25-ны өдөр тус тус залруулсан;
- Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 4,367.5 мянган төгрөг болж 9,285,390.4 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд хүлээн зөвшөөрсөн батлан даалтын зарлагын гүйлгээнээс тус тус шалтгаалсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээлийн эх үүсвэрээс 8,007,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг Сангийн яамнаас хянаж дүнгийн өөрчлөлгүй баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төслийн нэгжийн 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,007,200.0 мянган төгрөгийн төсөв баталсныг гадаад зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр өмнөх оны үлдэгдлээс 8,007,200.0 мянган төгрөг зарцуулж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд санхүүжилтийн орлого хүлээж аваагүй бөгөөд өмнөх оны мөнгөн хөрөнгийн төслийн ашиглаагүй үлдэгдлийг АХБ-д буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөг/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр	8,007,200.0	8,007,200.0	-	100.0
1.1	80104 Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ	8,007,200.0	8,007,200.0		100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл нь 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээ хэрэгжүүлж төслийн хэрэгжилтийн явц 99.9 хувьтай байна.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

д/д	Зорилтууд	Хүрэх үр дүн	Биелэлт	Хэрэг жилт
1	ЖДҮ-ийн илүү урт хугацаатай санхүүжилтийг нэмэгдүүлсэн байх	ЗБДС гурваас доошгүй шинэ батлан даалтын бүтээгдэхүүн гаргах, үүний дор хаяж нэг нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн бүтээгдэхүүн байх 2023 оны эцэст 57.13 сая ам.доллараас багагүй хэмжээний санхүүжилтийн ЗБДС-гийн батлан даалтыг ашиглаж буй ОСБ-уудад олгосон байх.	Ногоон батлан даалтын бүтээгдэхүүн, эмэгтэй ЖДҮҮЭ-ийг дэмжих батлан даалтын бүтээгдэхүүн, Экспортыг дэмжих батлан даалтын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн бол 2024 онд орон сууцны ипотекийн зээлийн батлан даалт, Хоршооны гишүүн-малчдын зээлийн батлан даалт, шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт гэсэн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн. ЗБДС нь 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар төслийн нийт санхүүжилт болох АХБ-аас татсан 60.0 сая ам.доллараас 58.27 сая ам.доллар (1 ам.доллар=2,752.97 төгрөг) санхүүжилтийг ОСБ-д шилжүүлсэн байна.	99.9
2	Банкны илүү урт хугацаат хадгаламжийн зах зээлийг бий болгосон байх	2023 он гэхэд ЗБДС-гийн төсөлд хамрагдсан 4-өөс доошгүй оролцогч санхүүгийн байгууллага 5 буюу түүнээс дээш жилийн хугацаат хадгаламжийг тогтмол санал болгодог байх.	2025 оны 12-р сарын 31-ны байдлаар ОСБ-ууд болох 7 арилжааны банкаар 5 буюу түүнээс дээш жилийн хугацаатай 58.27 сая ам.долларын (1 ам.доллар = 2,752.97 төгрөг) батлан даалттай зээлийг 528 ЖДҮҮ эрхлэгчдэд олгоод байна	100.0
3	ЗБДС ба зээлийн батлан даалтын тогтолцооны чанарыг сайжруулсан байх	2017 онд багтааж ЗБДС эрсдэлийн удирдлага болон санхүүгийн удирдлагын хоёр шинэ журмыг баталж хэрэгжүүлэх 2016 онд багтааж зээлийн батлан даалтын тогтолцооны хууль эрх зүйн орчныг сайжруулах нэмэлт өөрчлөлтүүдийг батлуулсан байх, үүнд хувийн хэвшлийн зээлийн батлан даалтын санг дэмжсэн нэмэлт өөрчлөлт багтана	Санхүүгийн удирдлагын журам нь ТУЗ-ийн 2018 оны 04-р сарын 25-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу батлагдсан ба хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын журам нь ТУЗ-ийн 2018 оны 8-р сарын 14-ны өдрийн 33 дугаар тушаалын дагуу батлагдсан ба 2019 оны 2-р сарын 25-ны өдөр болон 2022 оны 9-р сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор уг журмыг дахин шинэчлэн баталсан. Тайлант онд нийт 72 барьцаа хөрөнгө чөлөөлөх, солих, өөрчлөлт оруулах хүсэлтийн судалгаа, хугацаа хэтэрсэн 62 зээлд эрсдэлийн үнэлгээ хийсэн. ЗБДС-н тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг МБ-р ахлуулсан ажлын хэсэг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бол дэд даргаар ахлуулсан ЗГХЭГ-ын ажлын хэсэг ЗБДС-н тухай хуулийг бүрэн шинэчлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр УИХ-д өргөн мэдүүлэх хугацааг хойшлуулсан. 2021 оны 11-р сарын 12-ны өдөр ЗБДС-н тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн батлан даалт гаргах үүднээс ЗБДС-н тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Нийт дөрвөн удаа ЗБДС-	99.9

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			н тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан.	
		ЗБДС нь өөрийн орон нутгийн төлөөлөгчид болон ОСБ-тай хамтран маркетинг ба үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	Жил бүр ЗБДС-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар маркетингийн төлөвлөгөөг батлуулдаг. 2025 онд маркетингийн төлөвлөгөөг төслийн хувьд шаардлага үүсээгүй.	
		2016 онд багтааж зээлийн батлан даалтын тогтолцооны хууль эрх зүйн орчныг сайжруулах нэмэлт өөрчлөлтүүдийг батлуулсан байх, үүнд хувийн хэвшлийн зээлийн батлан даалтын санг дэмжсэн нэмэлт өөрчлөлтийг багтаасан байх.	2018 оны 11-р сарын 05-ны өдөр ЗБДС “НЭС” программыг Грэйп Сити ХХК-аас хүлээн авсан боловч шаардлага хангахгүйн улмаас Эрдэнэс Солюшн ХХК-аас шинэ программ түрээслэхээр гэрээ байгуулсан ба туршилт сайжруулалтын шатанд явагдаж дууссан байна.	
4	Сангийн гадаад, дотоод харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх	1.Олон улсын байгууллагын төслийн хэрэгжилтийг хангах, 2.Олон улсын батлан даалтын байгууллагуудтай холбоо тогтоох, судалгаа хийх, 3.Бусад гадаад хамтын ажиллагаа, 4.Дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх,	1.Гадаад хамтын ажиллагааны хүрээнд: Олон улсын батлан даалтын үйлчилгээ үзүүлдэг ГарантКо сүлжээ олон улсын байгууллагатай, БНСУ-н ЗБДСан болох Кодит байгууллагатай, БНУУ-н ЗБДСан болох Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх ХК-тай, БНКУ-н Батлан даалтын сан ТӨХК-тай, БНСУ-н Зээлийн батлан даалтын сангуудын холбоотой, Тайланд улсын ЗБДС-тай хамтран ажиллах, шинээр хамтарсан бүтээгдэхүүн гаргах санал солилцсон. 2.ЗБДС-н батлан даалт болон санхүүгийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн 2025-2030 оны санхүүгийн төсөөллийг шинэчлэн боловсруулсан.	99.9
Нийт дүн				99.9

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих, замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хөтөлбөрийн нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Болормаа, туслах аудитор Ц.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Ж.Жаргалсүрэн, компанийн захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитын менежер Э.Энхбаатар, газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих, замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний Аудитын Газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,285,390.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 92,853.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардал Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн тайланд тайлагнагддаг тул төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих, замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн үйл ажиллагааны мэдээллийг Зээлийн батлан даалтын сангийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8,310.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	8,310.0	1	8,310.0	100.0
Нийт дүн	1	8,310.0	1	8,310.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Доор дурдсан асуудлуудыг дараагийн аудитаар анхаарч үзэх зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих, замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр хаагдсан тул зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн батлан даалтын төлбөр тооцоог Зээлийн батлан даалтын санд бүрэн төвлөрүүлж баримтжуулсан эсэхийг шалгасан болно.

Төслийн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн 2025 оны жилийн эцсийн үлдэгдэл болох 4,367.5 мянган төгрөгийн хугацаат хадгаламжийн дансны үлдэгдлийг 2026 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөр цуцалж, үлдэгдлийг ЗБДС-н дансанд төвлөрүүлнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөхүйц алдаа, зөрчил илрээгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.